

## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР



### САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Монгол Улсын Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код:** САГ-2026/10/НА-СТА-ТЕЗ

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)  
Улаанбаатар хот  
2026 он

**Монгол Улсын Ерөнхий аудитор: С.Магнайсүрэн**  
Утас: 51-261885 Цахим хаяг: magnaisurens@audit.gov.mn  
**Тусгай чиг үүргийн газрын захирал,  
тэргүүлэх аудитор: Д.Баярсайхан**  
Утас: 51-261663 Цахим хаяг: bayarsaikhand@audit.gov.mn  
**Аудитын менежер: Э.Энхбаатар**  
Утас: 51-260512 Цахим хаяг: enkhbaatare@audit.gov.mn  
**Ахлах аудитор: П.Батцэцэг**  
Утас: 51-261628 Цахим хаяг: battsetsegp@audit.gov.mn  
**Аудитор: Ч.Мөнхбулган**  
Утас: 51-261628 Цахим хаяг: munkhbulganch@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

<b>1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ</b> .....	3
<b>2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ</b> .....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан .....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан .....	6
2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	6
2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	8
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	11
<b>3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА</b> .....	13
3.1 Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний үйл ажиллагаа .....	13
3.2 Төсвийн ерөнхийлөн захирагчийн гадаад, дотоод орчин .....	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	13
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд .....	14
3.4.1 Мөнгөн хөрөнгө .....	14
3.4.2 Авлага .....	16
3.4.3 Урьдчилгаа .....	16
3.4.4 Бараа материал .....	17
3.4.5 Бусад эргэлтийн хөрөнгө .....	18
3.4.6 Үндсэн хөрөнгө .....	18
3.4.7 Өр төлбөр .....	19
3.4.8 Засгийн газрын хувь оролцоо .....	20
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .....	20
3.5.1 Төсвийн төлөвлөлт .....	20
3.5.2 Төсвийн гүйцэтгэл .....	21
3.5.3 Нэмэлт төсөв .....	21
3.5.4 Тухайн жил худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэл .....	22
3.5.5 Хөтөлбөр арга хэмжээний хүрэх үр дүн, хэрэгжилт .....	24
<b>4. АУДИТЫН ТАЙЛАН</b> .....	27
4.1 Ерөнхий зүйл .....	27
4.2 Материаллаг байдал .....	27
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт .....	27
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	27
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	28
4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд .....	28
4.5 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн .....	29
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	29
<b>5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ</b> .....	30
5.1 Харьяа байгууллагуудын аудитаар илэрсэн алдаа, зөрчил .....	30
5.2 Төсвийн ерөнхийлөн захирагч .....	30
5.3 Түүврийн байгууллага- Жендэрийн үндэсний хорооны Ажлын алба .....	31
5.3.1 Албан шаардлага .....	31
5.3.2 Зөвлөмж .....	31
<b>6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ</b> .....	33
6.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл .....	33
6.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл .....	35
6.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	37

### Товчилсон үгийн жагсаалт

ААН	Аж ахуйн нэгж
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ГЗБА	Газар зохион байгуулалтын алба
ГЗБГЗЗЕГ	Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газар
ГХБХБГ	Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар
ЖҮХАА	Жендэрийн үндэсний хорооны Ажлын алба
МУЕС	Монгол Улсын Ерөнхий сайд
НҮБ	Нэгдсэн Үндэстний байгууллага
ТАХ	Төрийн албан хаагч
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ХХЗХ	Харилцаа холбооны зохицуулах хороо
УА	Удирдах ажилтан
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ХХЗХ	Харилцаа холбооны зохицуулах хороо
ЭХЗХ	Эрчим хүчний зохицуулах хороо



**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ АУДИТОР**

Засгийн газрын IV байр, Бага тойруу-3,  
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160  
Утас: 26-04-37, Факс: (976-51) 26 42 30  
Цахим шуудан: info@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

2026.04.24 № 1128  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Монгол Улсын Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Монгол Улсын Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүүгийн нэгтгэсэн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт "зөвшөөрлийн нэгдсэн бодлого"-ыг Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамруулахаар, Эрчим хүчний тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1-д "Аймаг, нийслэлд эрчим хүчний хангамжийн төрийн зохицуулалтыг аймаг, нийслэлийн зохицуулах зөвлөл хэрэгжүүлнэ" гэж заасан. Аймаг, нийслэлийн Эрчим хүчний зохицуулах зөвлөлүүд нь тухайн аймаг, сумдын дулаан хангамжийн асуудал буюу орон нутгийн хэрэглэгч, хангагч талуудын зохицуулалтыг хариуцдаг, орон тооны нягтлан бодогчгүй байгууллага бөгөөд оны эцэст гэрээт санхүүгийн ажилтны гаргасан тайланг Эрчим хүчний зохицуулах хорооноос хянах боломжгүй, шаардлагатай санхүүгийн тайлан, мэдээг цаг хугацаандаа, бүрэн авч, нэгтгэн тайлагнахад хүндрэлтэй байна.

## **Аудитын гол асуудал**

Тайлант онд Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газар нь харьяа 20 байгууллагын төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогын давж биелсэн 1,879.1 сая төгрөгийг ерөнхий газрын санхүүгийн тайланд нийт дүнгээр татаас, санхүүжилтийн авлагаар тайлагнаснаас шалтгаалж ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайланд үндсэн үйл ажиллагааны орлогыг нэмэгдүүлсэн байна.

## **Бусад асуудлын хэсэг**

Монгол улсын 2025 оны Төсвийн тухай хуулиар ерөнхийлөн захирагчийн улсын төсөвт төвлөрүүлэх ногдол ашиг болон түрээсийн орлогын хэмжээг 101,600.0 сая төгрөгөөр баталсан боловч гүйцэтгэлийг Төв төрийн сан дахь ногдол ашгийн болон түрээсийн орлогын дансанд шууд төвлөрүүлж, Сангийн яамны төрийн сангийн тайланд тайлагнасан байна.

## **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.


Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

## **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.



С.МАГНАЙСҮРЭН

## 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>137,577,992.8</b>	<b>157,887,140.5</b>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	59,612,359.5	66,540,489.6
33	АВЛАГА	7,575,389.7	13,343,793.3
34	УРЬДЧИЛГАА	30,037,957.1	31,585,919.0
35	БАРАА МАТЕРИАЛ	37,614,981.7	46,416,938.6
360	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	2,737,304.8	-
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>320,581,067.0</b>	<b>353,943,376.9</b>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	320,581,067.0	353,943,376.9
39200	Биет хөрөнгө	271,100,786.7	306,073,648.9
39300	Биет бус хөрөнгө	49,480,280.3	47,869,728.0
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>458,159,059.8</b>	<b>511,830,517.4</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>24,588,950.1</b>	<b>25,130,305.9</b>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	24,341,359.3	24,929,484.6
41300	Өглөг	23,756,135.3	24,536,648.1
41400	Урьдчилж орсон орлого	585,224.0	392,836.5
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	247,590.8	200,821.3
42200	Урт хугацаат зээл	247,590.8	200,821.3
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>433,570,109.7</b>	<b>486,700,211.5</b>
51	Засгийн газрын хувь оролцоо	433,570,109.7	486,700,211.5
51100	Засгийн газрын оруулсан капитал	41,798,168.7	41,851,549.7
51101	Өмч /төрийн/ /ТӨҮГ/	104,537.5	195,749.5
51106	Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/	2,175,079.3	2,217,441.5
51200	Хуримтлагдсан үр дүн	378,070,693.4	430,761,484.9
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	11,421,630.8	11,673,985.9
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>458,159,059.8</b>	<b>511,830,517.4</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН</b>	<b>866,790,554.1</b>	<b>685,241,864.4</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>83,324,347.0</b>	<b>685,241,864.4</b>
120	Нийтлэг татварын бус орлого	83,307,167.1	52,560,508.9
122	Тусламжийн орлого	17,179.9	632,681,355.5
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>783,466,207.1</b>	<b>-</b>
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>760,524,441.5</b>	<b>632,568,518.2</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>736,787,545.0</b>	<b>632,528,914.4</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>708,067,099.7</b>	<b>600,887,345.8</b>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	160,039,620.9	182,412,617.1
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	7,575,166.8	8,576,303.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,133,853.8	1,277,713.1
2104	Хангамж, бараа материалын зардал	1,638,764.6	3,581,143.7
2105	Нормативт зардал	22,728.1	22,978.1
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	497,494.8	444,943.6
2107	Томилолт, зочны зардал	1,170,721.4	1,055,099.9
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	408,966,801.9	268,093,182.2
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	127,021,947.4	135,423,365.1
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>28,720,445.3</b>	<b>31,641,568.6</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>23,736,896.5</b>	<b>39,603.8</b>
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН</b>	<b>106,266,112.6</b>	<b>52,673,346.2</b>
<b>IV</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН</b>	<b>277.0</b>	<b>1,141.5</b>
<b>V</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,589,562.7</b>	<b>146,117.9</b>
<b>VI</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН</b>	<b>(1,589,285.7)</b>	<b>(144,976.4)</b>
<b>VII</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН</b>	<b>104,676,826.9</b>	<b>52,528,369.8</b>

## 2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
<b>1</b>	<b>2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	344,572,879.2		344,572,879.2
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(14,814,491.3)		(14,814,491.3)
<b>3</b>	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>329,758,387.9</b>		<b>329,758,387.9</b>
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	(910,579.1)		(910,579.1)
7	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	45,474.0		45,474.0
<b>9</b>	<b>Тайлант үеийн үр дүн</b>	<b>104,676,826.9</b>		<b>104,676,826.9</b>
<b>10</b>	<b>2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>433,570,109.7</b>		<b>433,570,109.7</b>
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	295,995.9		295,995.9
<b>13</b>	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>433,866,105.6</b>		<b>433,866,105.6</b>
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	252,355.1		252,355.1
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	53,381.0		53,381.0
19	Тайлант үеийн үр дүн	52,528,369.8		52,528,369.8
<b>20</b>	<b>2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>486,700,211.5</b>		<b>486,700,211.5</b>

## 2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН</b>	<b>844,053,202.2</b>	<b>692,058,576.1</b>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	57,734,761.9	692,058,576.1
120	Нийтлэг татварын бус орлого	57,734,761.9	57,728,698.8
122	Тусламжийн орлого	-	634,329,877.3
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	786,318,440.3	-
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>287,829,768.7</b>	<b>334,747,973.9</b>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	287,829,768.7	334,747,973.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	263,000,643.2	305,063,199.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	171,309,864.4	195,635,536.5
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	9,316,386.1	8,618,078.4
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,234,812.4	1,371,314.1
2104	Хангамж, бараа материалын зардал	1,521,915.5	1,929,149.3
2105	Нормативт зардал	9,875.1	21,142.9
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	660,243.8	597,848.3
2107	Томилолт, зочны зардал	1,635,140.6	1,468,113.9
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	12,441,215.3	14,994,401.1
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	64,871,190.0	80,427,614.9
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	24,829,125.5	29,684,774.5
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>556,223,433.5</b>	<b>357,310,602.2</b>
<b>IV</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН</b>	<b>4,005.1</b>	<b>6,967.9</b>
140007	Хүлээн авсан хүүний орлого	4,005.1	6,967.9
<b>V</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>529,684,494.0</b>	<b>350,389,201.3</b>
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	529,684,494.0	350,389,201.3
2200	Дотоод эх үүсвэрээр	529,684,494.0	350,389,201.3
<b>VI</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>	<b>(529,680,488.9)</b>	<b>(350,382,233.4)</b>
<b>24</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО</b>	<b>256.2</b>	<b>1,139.3</b>
14	Бусад эх үүсвэр	256.2	1,139.3
<b>25</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ</b>	<b>1,108.4</b>	<b>1,378.0</b>
250001	Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	1,108.4	1,378.0
<b>VII</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН</b>	<b>(852.2)</b>	<b>(238.7)</b>
<b>VIII</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>26,542,092.4</b>	<b>6,928,130.1</b>
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	33,070,267.1	59,612,359.5
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	59,612,359.5	66,540,489.6

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН</b>	<b>380,915,587,100.00</b>	<b>362,330,065,399.75</b>	<b>18,585,521,700.25</b>	<b>95.1</b>
<b>Татварын бус орлого</b>	<b>380,915,587,100.00</b>	<b>362,330,065,399.75</b>	<b>18,585,521,700.25</b>	<b>95.1</b>
<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>3,548,972,300.00</b>	<b>6,968,305,156.98</b>	<b>(3,419,332,856.98)</b>	<b>196.3</b>
Төсөв байгууллагын өөрийн орлого /үндсэн/	2,151,897,300.00	4,126,501,324.95	(1,974,604,024.95)	191.8
Төсөв байгууллагын өөрийн орлого /туслах/	1,397,075,000.00	2,841,803,832.03	(1,444,728,832.03)	203.4
<b>Тусламжийн орлого</b>	<b>377,366,614,800.00</b>	<b>355,361,760,242.77</b>	<b>22,004,854,557.23</b>	<b>94.2</b>
Төсвөөс санхүүжих	377,366,614,800.00	355,361,760,242.77	22,004,854,557.23	94.2
<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>380,915,587,100.00</b>	<b>359,225,056,381.72</b>	<b>21,690,530,718.28</b>	<b>94.3</b>
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>335,421,532,000.00</b>	<b>317,521,723,941.39</b>	<b>17,899,808,058.61</b>	<b>94.7</b>
<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>334,269,560,900.00</b>	<b>316,630,415,869.24</b>	<b>17,639,145,030.76</b>	<b>94.7</b>
<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>186,455,981,400.00</b>	<b>179,583,602,844.31</b>	<b>6,872,378,555.69</b>	<b>96.3</b>
Үндсэн цалин	19,089,628,100.00	115,653,604,057.52	(95,563,975,957.52)	605.8
Нэмэгдэл	146,234,087,800.00	52,287,351,460.32	93,946,736,339.68	35.8
Унаа хоолны хөнгөлөлт	18,549,609,700.00	9,057,616,992.29	9,491,992,707.71	48.8
Урамшуулал	2,541,370,100.00	2,547,019,634.18	(5,649,534.18)	100.2
Гэрээт ажлын хөлс	41,285,700.00	38,010,700.00	3,275,000.00	92.1
<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>8,947,620,100.00</b>	<b>8,323,172,505.61</b>	<b>624,447,594.39</b>	<b>93.0</b>
Тэтгэврийн даатгал	4,433,372,900.00	5,876,610,744.36	(1,443,237,844.36)	132.6
Тэтгэмжийн даатгал	507,340,500.00	422,166,987.03	85,173,512.97	83.2
ҮОМШӨ-ний даатгал	254,664,800.00	217,827,132.31	36,837,667.69	85.5
Ажилгүйдлийн даатгал	247,256,900.00	201,294,744.57	45,962,155.43	81.4
Эрүүл мэндийн даатгал	3,504,985,000.00	1,605,272,897.34	1,899,712,102.66	45.8
<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>1,164,686,600.00</b>	<b>1,011,667,699.35</b>	<b>153,018,900.65</b>	<b>86.9</b>
Гэрэл, цахилгаан	95,357,800.00	95,099,414.73	258,385.27	99.7
Түлш, халаалт	534,488,500.00	470,449,549.37	64,038,950.63	88.0
Цэвэр, бохир ус	70,430,100.00	54,036,669.25	16,393,430.75	76.7
Байрны түрээс	464,410,200.00	392,082,066.00	72,328,134.00	84.4
<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>299,609,400.00</b>	<b>257,010,882.23</b>	<b>42,598,517.77</b>	<b>85.8</b>
Бичиг хэрэг	85,434,500.00	63,844,390.50	21,590,109.50	74.7
Тээвэр, шатахуун	82,925,200.00	84,119,252.00	(1,194,052.00)	101.4
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	85,801,800.00	77,983,647.73	7,818,152.27	90.9
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,752,200.00	683,000.00	1,069,200.00	39.0
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	43,695,700.00	30,380,592.00	13,315,108.00	69.5
<b>Нормативт зардал</b>	<b>2,524,900.00</b>	<b>322,900.00</b>	<b>2,202,000.00</b>	<b>12.8</b>
Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,524,900.00	322,900.00	2,202,000.00	12.8
<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>178,973,600.00</b>	<b>168,947,922.53</b>	<b>10,025,677.47</b>	<b>94.4</b>

Монгол Улсын Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Багаж, техник, хэрэгсэл	122,991,800.00	123,328,535.03	(336,735.03)	100.3
Тавилга	6,000,000.00	649,900.00	5,350,100.00	10.8
Урсгал засвар	49,981,800.00	44,969,487.50	5,012,312.50	90.0
<b>Томилолт, зочны зардал</b>	<b>189,093,700.00</b>	<b>168,809,366.00</b>	<b>20,284,334.00</b>	<b>89.3</b>
Гадаад албан томилолт	9,609,200.00	9,609,132.00	68.00	100.0
Дотоод албан томилолт	179,484,500.00	159,200,234.00	20,284,266.00	88.7
<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>5,981,012,700.00</b>	<b>3,926,700,659.80</b>	<b>2,054,312,040.20</b>	<b>65.7</b>
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,461,687,100.00	3,676,418,244.20	1,785,268,855.80	67.3
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	8,691,800.00	1,655,330.00	7,036,470.00	19.0
Даатгалын үйлчилгээ	20,260,100.00	9,162,359.00	11,097,741.00	45.2
Тээврийн хэрэгслийн татвар	4,890,800.00	3,395,523.00	1,495,277.00	69.4
Тээврийн хэрэгслийн оношилгоо	1,238,500.00	388,300.00	850,200.00	31.4
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	243,650,100.00	73,051,403.60	170,598,696.40	30.0
Газрын төлбөр	5,012,900.00	4,017,900.00	995,000.00	80.2
Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	235,581,400.00	158,611,600.00	76,969,800.00	67.3
<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>131,050,058,500.00</b>	<b>123,190,181,089.41</b>	<b>7,859,877,410.59</b>	<b>94.0</b>
Бараа үйлчилгээний бусад зардал	131,044,458,500.00	123,184,931,089.41	7,859,527,410.59	94.0
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,600,000.00	5,250,000.00	350,000.00	93.8
<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>1,151,971,100.00</b>	<b>891,308,072.15</b>	<b>260,663,027.85</b>	<b>77.4</b>
<b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>	<b>1,411,600.00</b>	-	<b>1,411,600.00</b>	-
Засгийн газрын гадаад шилжүүлэг	1,411,600.00	-	1,411,600.00	-
<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>1,150,559,500.00</b>	<b>891,308,072.15</b>	<b>259,251,427.85</b>	<b>77.5</b>
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	45,855,200.00	41,080,200.00	4,775,000.00	89.6
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	767,644,000.00	612,816,099.23	154,827,900.77	79.8
Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	321,464,300.00	237,411,772.92	84,052,527.08	73.9
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	15,596,000.00	-	15,596,000.00	-
<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>45,494,055,100.00</b>	<b>41,703,332,440.33</b>	<b>3,790,722,659.67</b>	<b>91.7</b>
Тоног төхөөрөмж	1,433,500,000.00	1,433,500,000.00	-	100.0
Бусад хөрөнгө	44,060,555,100.00	40,269,832,440.33	3,790,722,659.67	91.4
<b>ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ</b>	-	<b>3,105,009,018.03</b>	<b>(3,105,009,018.03)</b>	-
<b>АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	-	<b>(3,105,009,018.03)</b>	<b>3,105,009,018.03</b>	-
Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	-	(3,105,009,018.03)	3,105,009,018.03	-

Монгол Улсын Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>				
<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>19</b>	<b>19</b>	<b>-</b>	<b>100.0</b>
Төсвийн байгууллага	19	19	-	100.0
<b>АЖИЛЛАГСДЫН ТОО</b>	<b>1,100</b>	<b>1,073</b>	<b>27</b>	<b>97.5</b>
Удирдах ажилтан	27	26	1	96.3
Гүйцэтгэх ажилтан	970	943	27	97.2
Үйлчлэх ажилтан	103	103	-	100.0
Гэрээт ажилтан	-	1	(1)	-
<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>1,099</b>	<b>1,058</b>	<b>41</b>	<b>96.3</b>
Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	929	917	12	98.7
Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	57	62	(5)	108.8
Гэрээт ажилтан	-	1	(1)	-
Төрийн үйлчилгээний мэргэжлийн (ТҮМ)	113	78	35	69.0
<b>НИЙТ ТЭТГЭВЭРТ ГАРАГЧ</b>	<b>21</b>	<b>18</b>	<b>3</b>	<b>85.7</b>
Төрийн албаны тухай хуулиар тэтгэвэрт гарагч	21	18	3	85.7

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН</b>		<b>22,496,150,096.89</b>
<b>Татварын бус орлого</b>		<b>22,496,150,096.89</b>
<b>Тусламжийн орлого</b>		<b>22,496,150,096.89</b>
Хандив тусламж /дотоод/		22,496,150,096.89
Нэмэлт санхүүжилтийн орлого		22,496,150,096.89
Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		10,805,514,384.00
ЗГНХ, ЗДНХ, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухай төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		515,321,986.00
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		7,156,952,684.96
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		4,018,361,041.93
<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>		<b>21,602,313,397.69</b>
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>		<b>10,587,567,674.69</b>
<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>		<b>10,559,746,242.69</b>
<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>		<b>2,802,201,226.87</b>
Үндсэн цалин		574,496,467.04
Нэмэгдэл		1,202,090,644.50
Унаа хоолны хөнгөлөлт		70,936,193.93
Урамшуулал		250,871,799.33
Гэрээт ажлын хөлс		703,806,122.07
<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>		<b>294,905,857.39</b>
Тэтгэврийн даатгал		215,648,284.64
Тэтгэмжийн даатгал		19,293,976.29
ҮОМШӨ-ний даатгал		12,712,350.26
Ажилгүйдлийн даатгал		8,939,133.07
Эрүүл мэндийн даатгал		38,312,113.13
<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>		<b>157,114,937.16</b>
Гэрэл, цахилгаан		13,093,973.15
Түлш, халаалт		90,053,963.01
Цэвэр, бохир ус		5,577,001.00
Байрны түрээс		48,390,000.00
<b>Хангамж, бараа материалын зардал</b>		<b>943,923,228.40</b>
Бичиг хэрэг		371,080,322.00
Тээвэр, шатахуун		479,125,243.68
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр		25,866,526.72
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		881,700.00
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		66,969,436.00
<b>Нормативт зардал</b>		<b>20,820,000.00</b>
Хоол, хүнс		12,820,000.00
Нормын хувцас, зөөлөн эдлэл		8,000,000.00
<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>		<b>1,128,168,167.13</b>
Багаж, техник, хэрэгсэл		620,052,639.00
Тавилга		887,600.00
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл		38,514,000.00
Урсгал засвар		468,713,928.13
<b>Томилолт, зочны зардал</b>		<b>865,128,265.11</b>
Гадаад албан томилолт		9,804,000.00
Дотоод албан томилолт		855,324,265.11
<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>		<b>2,695,200,788.91</b>
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		2,678,590,104.91
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох		1,834,400.00
Даатгалын үйлчилгээ		4,479,745.00

Монгол Улсын Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Тээврийн хэрэгслийн татвар		395,929.00
Тээврийн хэрэгслийн оношилгоо		121,000.00
Мэдээлэл, технологийн үйлчилгээ		9,237,000.00
Газрын төлбөр		542,610.00
<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>		<b>1,652,283,771.72</b>
Бараа үйлчилгээний бусад зардал		1,489,728,887.72
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		162,554,884.00
<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>		<b>27,821,432.00</b>
<b>Бусад урсгал шилжүүлэг</b>		<b>27,821,432.00</b>
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал		25,530,000.00
Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг		491,432.00
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		1,800,000.00
<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>		<b>11,014,745,723.00</b>
Дотоод эх үүсвэрээр		11,014,745,723.00
Барилга байгууламж		10,750,596,923.00
Тоног төхөөрөмж		69,148,800.00
Бусад хөрөнгө		195,000,000.00
<b>ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ</b>		<b>893,836,699.20</b>
<b>АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>		<b>(893,836,699.20)</b>
Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт		(893,836,699.20)

### **3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА**

#### **3.1 Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний үйл ажиллагаа**

Монгол Улсын Ерөнхий сайд нь Монгол Улсын Үндсэн хуулийн 41 дүгээр зүйлийн 41.1-д “Ерөнхий сайд Засгийн газрыг удирдаж, төрийн хууль биелүүлэх ажлыг Улсын Их Хурлын өмнө хариуцна” гэж заасны дагуу яам, агентлагийн болон аймаг, нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааг зохицуулах чиг үүргийг хэрэгжүүлэхэд мэргэжлийн, цаг үеэ олсон, шуурхай зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх зэрэг үйл ажиллагаа явуулж байна.

#### **3.2 Төсвийн ерөнхийлөн захирагчийн гадаад, дотоод орчин**

Засгийн газрын тухай хуулийн 18<sup>1</sup> дугаар зүйлд “Засгийн газрын Хэрэг эрхлэх газар нь Засгийн газрын ажлын алба мөн”, “Хэрэг эрхлэх газрыг Засгийн газрын гишүүн тэргүүлнэ”, “Хэрэг эрхлэх газрын дарга Ерөнхий сайдын өмнө ажлаа хариуцна” гэж хуульчилсан байна.

Улсын Их Хурлын 1996 оны 38 дугаар тогтоолын дагуу Засгийн газрын Хэрэг эрхлэх газар нь Ерөнхий сайд, Засгийн газрын Танхимыг тэргүүлэн манлайлах чиг үүргийг дэмжих байгууллага бөгөөд “Үндэсний хэмжээнд тэргүүлэн манлайлах, стратегийн удирдамжаар хангах” ерөнхий чиг үүргийг хэрэгжүүлэхэд нь дор дурдсан үйл ажиллагааны хүрээнд дэмжин туслахаар заасан байна. Үүнд:

- Бодлогын үндсэн чиглэлийг тогтоож, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, тайлагнах, нөөцийн удирдлагаар хангах, гүйцэтгэх удирдлагаар хангах;
- Төрийн захиргааны байгууллагыг мэргэжлийн удирдлага, зохицуулалтаар хангах;
- Шинэтгэлийг санаачилж, түгээн дэлгэрүүлэх ажлыг эхэлж байх;
- Тогтвортой мэргэжлийн үйл ажиллагаагаараа төрийн захиргааны нийт байгууллагын үйл ажиллагааг дэмжих.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаанд өөрчлөлт ороогүй боловч, төсөвт байгууллагын санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-д өөрчлөлт орсон байна.

Удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй гэж үнэллээ.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд тусалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

#### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Монгол Улсын Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Монгол Улсын Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд Эрчим хүчний зохицуулах хороо нь тайлант оноос аймаг, нийслэлийн эрчим хүчний зохицуулах зөвлөлүүдийн санхүүгийн тайланг нэгтгэн санхүүгийн нэгтгэсэн тайлан гаргасантай холбогдуулан өмнөх оны хуримтлагдсан үр дүнгийн өөрчлөлт болон харьяа байгууллагуудын үндсэн хөрөнгө акталсантай холбоотой нягтлан бодох бүртгэлийн бодлогод 162.4 сая төгрөгийн өөрчлөлт орсон байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 53,671.4 сая төгрөгөөр буюу 10.5 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн үзүүлэлт /сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	59,612.3	66,540.5	6,928.2
Авлага	7,575.4	13,343.8	5,768.4
Урьдчилгаа	30,038.0	31,585.9	1,547.9
Бараа материал	37,615.0	46,416.9	8,801.9
Бусад эргэлтийн хөрөнгө	2,737.3	-	(2,737.3)
Үндсэн хөрөнгө	320,581.1	353,943.4	33,362.3
<b>Нийт хөрөнгө</b>	<b>458,159.1</b>	<b>511,830.5</b>	<b>53,671.4</b>
Өр төлбөр	24,589.0	25,130.3	541.3
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	433,570.1	486,700.2	53,130.1
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>458,159.1</b>	<b>511,830.5</b>	<b>53,671.4</b>

Эх сурвалж: МУЕС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

#### 3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 66,540.5 сая төгрөг болж, өмнөх оноос 6,928.1 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
<b>Кассад байгаа бэлэн мөнгө</b>	<b>7.4</b>	<b>15.0</b>	<b>7.6</b>
<b>Банканд байгаа бэлэн мөнгө</b>	<b>59,605.0</b>	<b>66,525.5</b>	<b>6,920.5</b>
<b>Төгрөг</b>	<b>59,582.6</b>	<b>66,502.3</b>	<b>6,919.7</b>
Төрийн сангийн харилцах	26,097.6	25,717.5	(380.1)
Арилжааны банк дахь харилцах	33,485.0	40,784.8	7,299.8
<b>Гадаад валют</b>	<b>22.4</b>	<b>23.2</b>	<b>0.8</b>
Арилжааны банк дахь харилцах	22.4	23.2	0.8
<b>Дүн</b>	<b>59,612.4</b>	<b>66,540.5</b>	<b>6,928.1</b>

Эх сурвалж: МУЕС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдлийн 61.3 хувь буюу 40,816.8 сая төгрөгийг төрийн өмчит үйлдвэрийн газрын, 38.7 хувь буюу 25,723.7 сая төгрөгийг төсөвт байгууллагын үлдэгдэл тус тус эзэлж байна.

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл өмнөх оноос 6,928.1 сая төгрөгөөр өсөхөд арилжааны банк дахь харилцахын үлдэгдэл 7,299.8 сая төгрөг, валютын арилжааны банк дахь харилцахын үлдэгдэл 0.8 сая төгрөг, кассад байгаа бэлэн мөнгө 7.6 сая төгрөгөөр тус тус нэмэгдэж, төрийн сангийн харилцахын үлдэгдэл 380.1 сая төгрөгөөр буурсан нь нөлөөлж байна.

Аудитын илрүүлэлт:

- Нийслэлийн ГЗБА улсын төсвийн санхүүжилттэй давхардуулан орон нутгийн төсвөөс цалин түүнтэй холбоотой татвар, нийгмийн даатгалын шимтгэлд 257.9 сая төгрөг төлсөн;
- Нийт 154.1 сая төгрөгийн зардлыг эдийн засгийн ангилал зөрүүлэн зарцуулсан (ГЗБГЗЗЕГ 53.9 сая төгрөг, Говь-Алтай аймгийн ГХБХБГ 34.1 сая төгрөг, ХХЗХ 25.1 сая төгрөг, ЖҮХАА 23.1 сая төгрөг, Дорноговь аймгийн ГХБХБГ 7.6 сая төгрөг, Завхан аймгийн ГХБХБГ 5.4 сая төгрөг, Дундговь аймгийн ГХБХБГ 2.2 сая төгрөг, Архангай аймгийн ГХБХБГ 2.0 сая төгрөг, Булган аймгийн ГХБХБГ 0.7 сая төгрөг);
- Анхан шатны баримтын бүрдэл дутуу нийт 112.1 сая төгрөгийг зарцуулсан (Төв аймгийн зохицуулах зөвлөл 42.0 сая төгрөг, Говь-Алтай аймгийн зохицуулах зөвлөл 30.6 сая төгрөг, Ховд аймгийн зохицуулах зөвлөл 20.1 сая төгрөг, Завхан аймгийн зохицуулах зөвлөл 7.8 сая төгрөг, Баян-Өлгийн аймгийн зохицуулах зөвлөл 5.6 сая төгрөг, Баянхонгор аймгийн ГХБХБГ 4.8 сая төгрөг, Дундговь аймгийн ГХБХБГ 1.2 сая төгрөг.);
- Нийт 67.7 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан (Завхан аймгийн ГХБХБГ 19.5 сая төгрөг, ЖҮХАА 19.5 сая төгрөг, ТӨБЗГ 10.9 сая төгрөг, Сэлэнгэ аймгийн ГХБХБГ 9.3 сая төгрөг, Сүхбаатар аймгийн ГХБХБГ 8.5 сая төгрөг);
- Нийслэлийн ГЗБА ээлжийн амралт биеэр эдлээгүй албан хаагчдад батлагдсан хуваарьт амраах боломжгүйг нотлох анхан шатны баримтын бүрдэл дутуу 41.6 сая төгрөгийн нөхөн олговор олгосон;
- Архангай аймгийн зохицуулах зөвлөл зохицуулалтын үйлчилгээний хөлсийг ЭХЗХ-оос баталсан аргачлалын дагуу тооцоогүй, тусгай зөвшөөрөл эзэмшигчидтэй үйлчилгээний хөлс төлөх гэрээг байгуулаагүй 34.3 сая төгрөгийг зарцуулсан;
- Говь-Алтай аймгийн ГХБХБГ тайлант онд автомашины урсгал засварт 22.8 сая төгрөг, ажилчдын нормын хувцас худалдан авахад 8.0 сая төгрөгийг зарцуулсан;
- Нийслэлийн ГЗБА байгууллагын дотоод журамд заагдсан цалинтай чөлөөг 28.1 сая төгрөгөөр эмчилгээ, асаргаа сувилгаанд 344 өдөр, сургалттай холбоотой 129 хоногийн шийдвэр гаргаж хавтгайруулан олгосон;
- Баянхонгор аймгийн ГХБХБГ захиалагчийн хяналтын зардлын төлбөрт 25.0 сая төгрөгийн гэрээ байгуулсан ч гэрээг дүгнээгүй, гэрээний төлбөрийг тайлант хугацаанд төсөвт төвлөрүүлээгүй;
- Нийт 20.3 сая төгрөгийн цалин урамшуулал олгосон боловч нийгмийн даатгалын тайланд мэдээлээгүй (Дундговь аймгийн зохицуулах зөвлөл 16.1 сая төгрөг, Баянхонгор аймгийн ГХБХБГ 4.2 сая төгрөг);
- Нийт 18.8 сая төгрөгийн зардлын төсвийг хэтрүүлэн зарцуулсан (Говь-Алтай аймгийн зохицуулах зөвлөл 15.5 сая төгрөг, Төв аймгийн зохицуулах зөвлөл 3.3 сая төгрөг);
- Нийт 16.9 сая төгрөгийн үр дүнгийн урамшууллыг илүү тооцож олгосон (Архангай аймгийн зохицуулах зөвлөл 7.8 сая төгрөг, Дундговь аймгийн зохицуулах зөвлөл 4.9 сая төгрөг, Өвөрхангай аймгийн 1.9 сая төгрөг, Дархан-Уул аймгийн ГХБХБГ 1.5 сая төгрөг, Баян-Өлгий аймгийн ГХБХБГ 0.8 сая төгрөг);
- Нийт 13.5 сая төгрөгийн албан томилолтоор ажилласан албан хаагчдад унаа, хоолны хөнгөлөлтийг давхардуулан олгосон (Өмнөговь аймгийн ГХБХБГ 11.9 сая төгрөг, Завхан аймгийн ГХБХБГ 1.6 сая төгрөг);
- Нийт 12.6 сая төгрөгийн Төрийн хэмнэлтийн тухай хуульд нийцэхгүй зардал гаргасан (ХХЗХ 9.7 сая төгрөг, Бусад 2.9 сая төгрөг);
- Нийт 10.6 сая төгрөгийн ур чадварын нэмэгдлийг бодитой тооцож үнэлээгүй, илүү тооцож олгосон (Дархан-Уул аймгийн ГХБХБГ 7.6 сая төгрөг, Орхон аймгийн ГХБХБГ 3.0 сая төгрөг);
- Говьсүмбэр аймгийн ГХБХБГ Ёс зүйн дэд хорооны гишүүдэд нийт 6.7 сая төгрөгийн урамшууллыг ажлыг үр дүн, гүйцэтгэлийг харгалзан бодитой үнэлээгүй, ёс зүйн дэд хороонд өргөдөл, гомдол ирээгүй, ямар нэгэн асуудал шийдвэрлээгүй байхад олгосон;
- Говь-Алтай аймгийн ГХБХБГ өндөр насны тэтгэвэрт гарсан 2 албан хаагчид тэтгэмжийг тооцохдоо 1 албан хаагчид 0.7 сая төгрөг илүү, 1 албан хаагчид 5.1 сая төгрөг дутуу тооцож олгосон;

- Хэнтий аймгийн ГХБХБГ тайланд онд 16 албан хаагчид илүү цагийн хөлсөнд 3.6 сая төгрөгийг олгосон.

### 3.4.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 13,343.7 сая төгрөг болж, өмнөх оноос 5,768.3 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчтай холбоотой авлага	78.2	127.1	48.9
Төлбөртэй үйлчилгээний авлага	5,447.0	6,465.5	1,018.5
Татаас, санхүүжилтийн авлага	680.7	3,662.0	2,981.3
Дансны авлага /ТӨҮГ/	186.0	257.7	71.7
Татвар, НДШ-ийн авлага /ТӨҮГ/	60.7	20.8	(39.9)
<b>Бусад авлага</b>	<b>1,122.8</b>	<b>2,810.6</b>	<b>1,687.8</b>
Байгууллагаас авах авлага	831.6	2,698.6	1,867.0
Хувь хүмүүсээс авах авлага	291.2	112.0	(179.2)
<b>Дүн</b>	<b>7,575.4</b>	<b>13,343.7</b>	<b>5,768.3</b>

Эх сурвалж: МУЕС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нийт авлагын үлдэгдлийн 55.5 хувь буюу 7,139.3 сая төгрөгийг төсөвт байгууллага, 46.5 хувь буюу 6,204.4 сая төгрөгийг төрийн өмчит үйлдвэрийн газар тус тус эзэлж байна.

Авлагын үлдэгдэл 5,768.3 сая төгрөгөөр өсөхөд Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын Сангийн сайдын 2026 оны “Улсын төсвийн байгууллагын үйл ажиллагааны давсан орлогоос зарцуулах эрх олгох тухай” 24 дүгээр тушаалаар татаас, санхүүжилтийн авлага дансны үлдэгдэл 1,879.1 сая төгрөг, Барилгын хөгжлийн төвөөс авах он дамжсан барилга, их засварын захиалагчийн техник хяналтын орлого 1,585.9 сая төгрөг, Харилцаа холбооны зохицуулах хорооны төлбөртэй үйлчилгээний авлага 1,895.0 сая төгрөг, хуримтлуулж тооцсон хадгаламжийн хүүгийн авлага 1,067.2 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэн нь голлон нөлөөлсөн байна.

#### Аудитын илрүүлэлт:

- ГЗБГЗЗЕГ тайлант онд харьяа 20 байгууллагын үндсэн үйл ажиллагааны орлогын гүйцэтгэл төлөвлөгөөнөөс давж биелсэн, давсан 1,879.1 сая төгрөгийн орлогыг нийт дүнгээр ГЗБГЗЗЕГ-ын аппаратын санхүүгийн тайланд татаас, санхүүжилтийн авлагаар хүлээн зөвшөөрч бүртгээсэн нь нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайланд төсөвт байгууллагын өөрийн орлогыг давхардуулан тайлагнасан;
- ТӨБЗГ улсын төсөвт төвлөрүүлэх түрээсийн орлогын 101.6 сая төгрөгийг өөрийн үндсэн үйл ажиллагааны орлогоор хүлээн зөвшөөрч, татаас, санхүүжилтийн авлагаар бүртгэж тайлагнасан;
- Нийт 34.2 сая төгрөгийн авлага, өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй (Баян-Өлгий аймгийн зохицуулах зөвлөл 28.1 сая төгрөг, Говь-Алтай аймгийн зохицуулах зөвлөл 6.1 сая төгрөг);
- Архангай аймгийн ГХБХБГ Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шийдвэрийг үндэслэн 10.1 сая төгрөгийг байгууллагын төсвөөс олгосон;
- Дорнод аймгийн зохицуулах зөвлөл 4.0 сая төгрөгийн хувь хүнээс авах авлагыг барагдуулаагүй байна.

### 3.4.3 Урьдчилгаа

Урьдчилгаа дансны эцсийн үлдэгдэл 31,585.9 сая төгрөг болж, өмнөх оноос 1,547.9 сая төгрөгөөр өссөн байна.

Монгол Улсын Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Хүснэгт 4. Урьдчилгаа дансны үлдэгдэл

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
<b>Урьдчилж гарсан зардал</b>	<b>13,995.5</b>	<b>27,744.9</b>	<b>13,749.4</b>
<b>Урьдчилгаа тооцоо</b>	<b>16,042.5</b>	<b>3,841.0</b>	<b>(12,201.5)</b>
Бараа материал бэлтгэх урьдчилгаа	1.1	-	(1.1)
Үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа	16,030.8	3,841.0	(12,189.8)
Цалингийн урьдчилгаа	1.0	-	(1.0)
Томилолтын урьдчилгаа	9.6	-	(9.6)
<b>Дүн</b>	<b>30,038.0</b>	<b>31,585.9</b>	<b>1,547.9</b>

Эх сурвалж: МУЕС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Урьдчилгаа дансны үлдэгдэл 1,547.9 сая төгрөгөөр өсөхөд Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын Нийслэлийн ГЗБА-ны иргэн, ААН байгууллагын газрын нөхөн олговрын урьдчилгаа 27,657.7 сая төгрөг, ГЗБГЗЗЕГ-ын гэрээт ажлуудын он дамжсан гэрээний төлбөрийн үлдэгдэл 58.9 сая төгрөг нь голлон нөлөөлсөн байна.

### 3.4.4 Бараа материал

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 46,416.9 сая төгрөг болж, өмнөх оноос 8,801.9 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 5. Бараа материалын үлдэгдэл

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
<b>Түүхий эд материал</b>	<b>17,060.0</b>	<b>19,123.8</b>	<b>2,063.8</b>
Тусгай зориулалттай материал	16,906.4	19,000.3	2,093.9
Эм боох материал	153.6	123.5	(30.1)
<b>Дуусаагүй үйлдвэрлэл</b>	<b>168.5</b>	<b>701.4</b>	<b>532.9</b>
<b>Бэлэн бүтээгдэхүүн</b>	<b>302.4</b>	<b>310.7</b>	<b>8.3</b>
<b>Хангамжийн материал</b>	<b>17,321.3</b>	<b>21,732.3</b>	<b>4,411.0</b>
Бичиг хэргийн материал	394.8	497.5	102.7
Аж ахуйн материал	7,981.9	10,908.6	2,926.7
Сэлбэг хэрэгсэл	1,700.1	1,707.2	7.1
Түлш, шатах тослох материал	685.3	873.5	188.2
Барилгын засварын материал	53.0	75.8	22.8
Хүнсний материал	281.8	334.7	52.9
Бусад хангамжийн материал	6,224.4	7,335.0	1,110.6
<b>Биологийн хөрөнгө</b>	<b>2,631.4</b>	<b>4,345.9</b>	<b>1,714.5</b>
<b>Мал амьтад</b>	<b>131.4</b>	<b>202.8</b>	<b>71.4</b>
<b>Дүн</b>	<b>37,615.0</b>	<b>46,416.9</b>	<b>8,801.9</b>

Эх сурвалж: МУЕС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материал дансны үлдэгдлийн 23.4 хувийг түүхий эд материал, 6.1 хувийг дуусаагүй үйлдвэрлэл, 0.1 хувийг бэлэн бүтээгдэхүүн, 50.1 хувийг хангамжийн материал, 19.5 хувийг биологийн хөрөнгө, 0.8 хувийг мал амьтад тус тус эзэлж байна.

Тодруулга тайлангаар бараа материал худалдан авсан 23,543.8 сая төгрөг, хандиваар 9.5 сая төгрөг, бүтцийн өөрчлөлтөөр шилжүүлэн авсан 2,058.8 сая төгрөг, бусад 3,351.2 сая төгрөг, нийт 28,963.3 сая төгрөгөөр нэмэгдэж, зарцуулсан 16,137.3 сая төгрөг, шилжүүлсэн 1,184.3 сая төгрөг, бүтцийн өөрчлөлтөөр шилжүүлсэн 25.2 сая төгрөг, бусад 2,814.6 сая төгрөг, нийт 20,161.4 сая төгрөгөөр хасагдсан байна.

Аудитын илрүүлэлт:

- ТӨБЗГ түлш, шатах тослох материалыг 22.8 сая төгрөгөөр нөөцөлсөн;
- Нийт 16.8 сая төгрөгийн шатахуун илүү зарцуулсан (Ховд аймгийн зохицуулах зөвлөл 3.7 сая төгрөг, Дархан-Уул аймгийн ГХБХБГ 3.6 сая төгрөг, Орхон аймгийн зохицуулах зөвлөл 2.8 сая төгрөг, Өмнөговь аймгийн ГХБХБГ 2.1 сая төгрөг, Архангай аймгийн ГХБХБГ 1.8 сая төгрөг, Завхан аймгийн зохицуулах зөвлөл 1.7 сая төгрөг, Орхон аймгийн ГХБХБГ 1.1 сая төгрөг);

Монгол Улсын Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

- Нийт 8.4 сая төгрөгийн бараа материалыг анхан шатны баримтын бүрдэл дутуу зарлагадсан (Архангай аймгийн зохицуулах зөвлөл 2.9 сая төгрөг, Булган аймгийн зохицуулах зөвлөл 2.3 сая төгрөг, Сүхбаатар аймгийн зохицуулах зөвлөл 1.6 сая төгрөг, Баянхонгор аймгийн зохицуулах зөвлөл 0.8 сая төгрөг, Говьсүмбэр аймгийн зохицуулах зөвлөл 0.8 сая төгрөг);
- ТӨБЗГ аудитын түүвэрчилсэн тооллогоор бараа материалын дансанд бүртгэлтэй 2.7 сая төгрөгийн хөрөнгө биетээр оршин байхгүй;
- Өмнөговь аймгийн ГХБХБГ 2.4 сая төгрөгийн бичгийн цаас, принтерийн хорны үлдэгдэлтэй тайлагнасан.

### 3.4.5 Бусад эргэлтийн хөрөнгө

Бусад эргэлтийн хөрөнгө дансны эцсийн үлдэгдэл өмнөх оноос 2,737.3 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 6. Бусад эргэлтийн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Бусад эргэлтийн хөрөнгө /ТӨҮГ/+Бусад	2,737.3	-	(2,737.3)
<b>Дүн</b>	<b>2,737.3</b>	<b>-</b>	<b>(2,737.3)</b>

Эх сурвалж: МУЕС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

ТӨБЗГ-ын бусад эргэлтийн хөрөнгөд бүртгэлтэй аймаг, нийслэлийн Мэргэжлийн хяналтын газруудад ашиглаж байсан 1,677.3 сая төгрөгийг хөдлөх хөрөнгүүдийг ТӨБЗГ-ын 2025 оны 517 дугаар тогтоолоор орон нутгийн өмчид шилжүүлсэн, мөн улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл мэдээллийн системийн тоног төхөөрөмж, мэдээллийн системийг хүлээн авч 1,060.0 сая төгрөгөөр үндсэн хөрөнгөд бүртгэсэн зэрэг нь бусад эргэлтийн хөрөнгө дансны үлдэгдлийг 2,737.3 сая төгрөгөөр буурахад нөлөөлсөн байна.

### 3.4.6 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгө дансны эцсийн үлдэгдэл цэвэр дүнгээр 353,943.4 сая төгрөг болж, өмнөх оноос 33,362.3 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 7. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
<b>Биет хөрөнгө</b>	<b>271,100.8</b>	<b>306,073.6</b>	<b>34,972.8</b>
Барилга, байгууламж, орон сууц	148,847.9	160,547.5	11,699.6
Авто-тээврийн хэрэгсэл	27,883.8	43,776.1	15,892.3
Машин тоног төхөөрөмж(компьютер)	79,004.6	85,262.4	6,257.8
Тавилга, аж ахуйн эд хогшил	8,629.8	9,566.9	937.1
Зам, гүүрийн байгууламж	10.4	4.8	(5.6)
Бусад үндсэн хөрөнгө	6,508.2	6,678.8	170.6
Батлан хамгаалах, цэргийн зориулалттай тоног төхөөрөмж	103.4	103.4	-
Ном	112.7	133.7	21.0
<b>Биет бус хөрөнгө</b>	<b>49,480.3</b>	<b>47,869.8</b>	<b>(1,610.5)</b>
Программ хангамж	33,101.4	28,300.2	(4,801.2)
Бусад биет бус хөрөнгө	16,378.9	19,569.6	3,190.7
<b>Дүн</b>	<b>320,581.1</b>	<b>353,943.4</b>	<b>33,362.3</b>

Эх сурвалж: МУЕС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдлийн 86.5 хувь буюу 306,073.6 сая төгрөгийг биет хөрөнгө, 13.5 хувь буюу 47,869.8 сая төгрөгийг биет бус хөрөнгө эзэлж байна.

Тодруулга тайлангаар үндсэн хөрөнгө худалдан авсан 87,939.0 сая төгрөг, хандиваар 485.1 сая төгрөг, балансаас баланст шилжүүлэн хүлээн авсан 25,165.5 сая төгрөг, бүтцийн өөрчлөлтөөр шилжүүлэн авсан 914.7 сая төгрөг, бусад 7,465.1 сая төгрөг, дахин үнэлгээний нэмэгдэл 1,279.0 сая төгрөг, нийт 123,248.4 сая төгрөгөөр нэмэгдэж, ТӨБЗГ-ын шийдвэрээр акталж данснаас хассан 2,752.9 сая төгрөг, балансаас баланст шилжүүлсэн 23,624.0 сая төгрөг, бүтцийн

өөрчлөлтөөр шилжүүлсэн 646.7 сая төгрөг, бусад 1,637.1 сая төгрөг, дахин үнэлгээний хорогдол 1,011.4 сая төгрөг, нийт 29,672.1 сая төгрөгөөр хасагдаж, тайлант оны элэгдлийн зардал 66,667.8 сая төгрөгөөр буурсан байна.

Аудитын илрүүлэлт:

- Нийт 86.6 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг худалдан авахдаа тушаал, шийдвэргүй, холбогдох хууль тогтоомжийг мөрдөөгүй худалдан авалт хийсэн (Өмнөговь аймгийн ГХБХБГ 77.4 сая төгрөг, Ховд аймгийн зохицуулах зөвлөл 9.2 сая төгрөг);
- ХХЗХ Үндсэн хөрөнгийн дансанд элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн 18.5 сая төгрөгийн хөрөнгийн ашиглах хугацаа, өртгийг шинэчлэн тогтоогоогүй;
- Үндсэн хөрөнгийн жилийн эцсийн тооллогыг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн тоолж, илтгэх хуудаст тусгаагүй, хөрөнгийн ашиглалт, хамгаалалт хангалтгүй, санхүүгийн программд хөрөнгийг бүртгэхдээ тухайн хөрөнгийн мэдээллийг бүрэн бүртгээгүй (Говь-Алтай аймгийн зохицуулах зөвлөл 15.3 сая төгрөг, ТӨБЗГ, Говь-Алтай аймгийн ГХБХБГ).

**3.4.7 Өр төлбөр**

Нийт өр төлбөрийн дансны эцсийн үлдэгдэл 25,130.3 сая төгрөг болж, өмнөх оноос 541.3 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 8. Нийт өр төлбөрийн үлдэгдэл / сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагсадтай холбогдсон өглөг	4.1	366.3	362.2
Бараа үйлчилгээний зардлын өглөг	0.9	65.5	64.6
Байгууллагад төлөх өглөг	23,750.4	23,958.8	208.4
Хувь хүмүүст төлөх өглөг	0.1	130.5	130.4
Татварын өглөг /ТӨҮГ/	-	8.2	8.2
НДШ-ийн өглөг /ТӨҮГ/	0.7	2.8	2.1
Дансны өглөг /ТӨҮГ/	-	4.6	4.6
Урьдчилж орсон орлого	585.2	392.8	(192.4)
Урт хугацаат өр төлбөр /ТӨҮГ/	247.6	200.8	(46.8)
<b>Дүн</b>	<b>24,589.0</b>	<b>25,130.3</b>	<b>541.3</b>

Эх сурвалж: МУЕС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нийт өр төлбөрийн 97.6 хувь буюу 24,536.7 сая төгрөг нь богино хугацаат өр төлбөр, 0.8 хувь буюу 200.8 сая төгрөг нь урт хугацаат өр төлбөр, 1.6 хувь буюу 392.8 сая төгрөг нь урьдчилж орсон орлого тус тус эзэлж байна.

Богино хугацаат өр төлбөрийн үлдэгдэл 208.4 сая төгрөгөөр өссөн нь Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын гэрээт ажлын үлдэгдэл 2,734.9 сая төгрөгийн байгууллагад төлөх өглөг үүссэн нь голлон нөлөөлсөн байна.

Урьдчилж орсон орлого дансанд Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын 189.6 сая төгрөг, Харилцаа холбооны зохицуулах хорооны 161.3 сая төгрөг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 39.0 сая төгрөг, Эрчим хүчний зохицуулах хорооны 0.4 сая төгрөгийн орлого тус тус бүртгэлтэй байна.

Урт хугацаат өр төлбөр дансны үлдэгдэлд Эрчим хүчний зохицуулах хорооны Нэгдсэн Үндэстний байгууллагын хөгжлийн хөтөлбөрийн “НАМА” төслөөр хандивласан хөрөнгө болон Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгээс хэрэгжүүлсэн “Эрчим хүчний үр ашиг 3+” төслийн тухайн жилд ногдох орлого 46.7 сая төгрөгийг хасаж, хойшлогдсон 200.8 сая төгрөгийн орлогыг тайлант хугацаанд бүртгэсэнтэй холбоотой байна.

Аудитын илрүүлэлт:

- Дархан-Уул аймгийн ГХБХБГ 3.6 сая төгрөгийн өр төлбөрийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй;

- Төв аймгийн ГХБХБГ байгууллагад төлөх өглөгийн дүнг 3.3 сая төгрөгөөр зөрүүтэй тооцоолсон.

### 3.4.8 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 486,700.2 сая төгрөг болж, өмнөх оноос 53,130.1 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 9. Засгийн газрын хувь оролцоо

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	41,798.2	41,851.6	53.4
Өмч /төрийн/ /ТӨҮГ/	104.5	195.7	91.2
Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/	2,175.1	2,217.4	42.3
<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>378,070.7</b>	<b>430,761.5</b>	<b>52,690.8</b>
Өмнөх үеийн үр дүн	273,393.9	378,233.1	104,839.2
Тайлант үеийн үр дүн	104,676.8	52,528.4	(52,148.4)
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	11,421.6	11,674.0	252.4
<b>Дүн</b>	<b>433,570.1</b>	<b>486,700.2</b>	<b>53,130.1</b>

Эх сурвалж: МУЕС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 52,528.4 сая төгрөгөөр, дахин үнэлгээний зөрүү 252.4 сая төгрөгөөр нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.3-д заасны дагуу Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлд Монгол Улсын Ерөнхий сайдын төсвийн багцын зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 580,351.9 сая төгрөг, үйл ажиллагааны орлогоос 4,697.5 сая төгрөг, бараа, үйлчилгээний зардлыг 374,533.4 сая төгрөг, урсгал шилжүүлгийн зардлыг 1,845.8 сая төгрөг, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх хөрөнгийн зардлыг 208,670.2 сая төгрөгөөр төлөвлөж, төсвийн саналыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас хөрөнгийн зардлыг 50,992.6 сая төгрөгөөр нэмэгдүүлж, бараа үйлчилгээний зардлыг 8,524.0 сая төгрөг, урсгал шилжүүлгийн зардлыг 543.2 сая төгрөгөөр тус тус бууруулж, Нийт зарлага ба цэвэр зээлийг 626,974.8 сая төгрөгөөр баталсан байна.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиар төсвийн захирагчийн зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 377,366.6 сая төгрөгийг улсын төсвөөс, 3,549.0 сая төгрөгийг үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос бүрдүүлэхээр, бараа, үйлчилгээний зардлыг 31,713.2 сая төгрөг, урсгал шилжүүлгийн зардлыг 177.3 сая төгрөг, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх хөрөнгийн зардлыг 214,168.7 сая төгрөг, нийт зарлага цэвэр зээлийн дүнг 246,059.2 сая төгрөгөөр бууруулж, нийт зарлага ба цэвэр зээлийг 380,915.6 сая төгрөгөөр тодотгон баталсан байна.

Төсвийн захирагч Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлд ногдол ашгийн орлогыг 49,000.0 сая төгрөг, түрээсийн орлогыг 1,600.0 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлэхээр төлөвлөн төсвийн саналыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлсэн боловч саналыг 51,000.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэн Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулиар ногдол ашгийн орлого 100,000.0 сая төгрөг, түрээсийн орлого 1,600.0 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлэхээр баталсан байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

#### Улсын төсвийн орлого бүрдүүлэлт

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулиар ногдол ашгийн 101,600.0 сая төгрөгийн орлого төвлөрүүлэхээр баталснаас Төрийн өмчид ногдох хувьцааны ногдол ашиг 34,593.0 сая төгрөг, төрийн өмчийг түрээсэлсэн түрээсийн орлого 1,066.0 сая төгрөг, өмч, хувьчлалын орлого 75.8 сая төгрөг, нийт 35,734.8 сая төгрөгийг бүрдүүлсэн байна.

#### Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн зарцуулалт

Гүйцэтгэлээр улсын төсвөөс урсгал зардлын санхүүжилтэд 317,521.7 сая төгрөг, улсын төсвийн хөрөнгө оруулалтын зардалд 41,703.3 сая төгрөг, үйл ажиллагааны орлогоос 6,968.3 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, 24,900.3 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл төлөвлөснөөс 95.1 хувь буюу 362,330.1 сая төгрөгийн гүйцэтгэлтэй гарсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансанд нийт 22,496.2 сая төгрөгийн орлого /төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж 10,805.5 сая төгрөг, Засгийн газрын нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 515.3 сая төгрөг, дээд шатны төсөвт тусгагдсан төсвөөс 7,157.0 сая төгрөг, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 4,018.4 сая төгрөг/ -ыг бүрдүүлсэн байна.

Санхүүжилтийн гүйцэтгэлээр цалин хөлс болон нэмэгдэл урамшуулалд 2,802.2 сая төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалын шимтгэлд 294.9 сая төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд 157.1 сая төгрөг, хангамж, бараа материалын зардалд 943.9 сая төгрөг, нормативт зардалд 20.8 сая төгрөг, эд хогшил, урсгал засварын зардалд 1,128.2 сая төгрөг, томилолт, зочны зардалд 865.1 сая төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд 2,695.2 сая төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 1,652.3 сая төгрөг, урсгал шилжүүлгийн зардалд 27.8 сая төгрөг, хөрөнгийн зардалд 11,014.7 сая төгрөгийг зарцуулж, 877.1 сая төгрөгийг улсын төсөвт, 16.8 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Жендэрийн үндэсний хорооны ажлын алба нь НҮБ-ын Хүн амын сантай хамтран хэрэгжүүлж буй MNG07GSN “Монгол Улсад жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний чадавхыг бэхжүүлэх нь” төслийн санхүүжилтээр 541.0 сая төгрөгийг хүлээн авч, Хүний эрхийн үндэсний комиссын хүний эрхийн сургалтын багцын Жендэрийн хүний эрхийн бүрэлдэхүүн хэсгийг шинэчлэн боловсруулж, сургагч багш бэлтгэх, Иргэний нийгмийн байгууллагад зориулсан Monitoring tool боловсруулах, жендэрийн мэргэшсэн шинжээч, үндэсний сургагч багшийн багийн гишүүдийн улирал тутмын уулзалтыг зохион байгуулах, Жендэрийн тэгш байдлыг хангуулахад хамтран ажиллах ахисан түвшинд бэлтгэгдсэн жендэрийн мэргэшсэн шинжээч, үндэсний сургагч багийн багийн 30 гишүүн жендэрийн асуудлаарх сургалт, хяналт- шинжилгээ, үнэлгээ хийх чиглэлээр дэмжлэг үзүүлэх орон нутгийн жендэрийн мэргэжилтнүүдэд зориулсан менторшип хөтөлбөр хэрэгжүүлэх зэрэг үйл ажиллагаанд зарцуулан нэмэлт санхүүжилтийн тайланд тусгасан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

#### Аудитын илрүүлэлт:

- ГЗБГЗЗЕГ техник хяналтын зардлын данснаас 50.0 сая төгрөгийг нэмэлт санхүүжилтийн дансанд шилжүүлэн байгууллагын үндсэн үйл ажиллагаанд зарцуулсан.

### 3.5.4 Тухайн жил худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэл

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны бараа, ажил, үйлчилгээний худалдан авах төлөвлөгөөнд 123 арга хэмжээг хэрэгжүүлэхээр 12,294.7 сая төгрөг баталсан байна.

Худалдан авалтын төлөвлөгөөнд 9,672.0 сая төгрөгийн 24 төсөл, арга хэмжээг нээлттэй сонгон шалгаруулалт, 1,204.1 сая төгрөгийн 22 арга хэмжээг харьцуулалтын аргаар, 1,418.6 сая төгрөгийн 77 арга хэмжээг шууд гэрээ байгуулахаар баталжээ.

Гүйцэтгэлээр 7,601.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 132 бараа, ажил үйлчилгээнд худалдан авах ажиллагааг зохион байгуулж, 5,032.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 21 бараа, ажил, үйлчилгээг нээлттэй тендер шалгаруулалтын аргаар, 237.8 сая төгрөгийн 1 барааг нэг эх үүсвэрээс худалдан авах аргаар, 50.2 сая төгрөгийн 1 барааг ерөнхий гэрээний аргаар, 1,318.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 29 бараа, ажил, үйлчилгээг харьцуулалтын аргаар, 962.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 80 бараа, ажил, үйлчилгээг шууд худалдан авах аргаар зохион байгуулж, гүйцэтгэгчтэй гэрээ байгуулсан байна.

#### Аудитын илрүүлэлт:

- Нийт 424.0 сая төгрөгийн худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа төсөвт өртөгийн дээд хязгаарт багтааж, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгаж, тодотголд хийгээгүй шууд худалдан авалт хийж санхүүжилт олгосон (ГЗБГЗЗЕГ 244.9 сая төгрөг Өвөрхангай аймгийн ГХБХБГ 96.3 сая төгрөг, Хөвсгөл аймгийн ГХБХБГ 82.8 сая төгрөг);
- Жендэрийн үндэсний хороо Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлээгүй, 9 хуулийн этгээдтэй 159.2 сая төгрөгийн шууд гэрээ байгуулж, санхүүжилт олгосон;
- ХХЗХ 57.8 сая төгрөгийн Цахим эрсдэлээс хүүхэд хамгаалах багц хичээлийн агуулга боловсруулах зөвлөх үйлчилгээний худалдан авах ажиллагааг тендерийн өгөгдлийн хүснэгтэд заасан шаардлагад нийцүүлж үнэлээгүй;
- ГЗБГЗЗЕГ Газрын зургийн системийн техник, эдийн засгийн үндэслэл (ТЭЗҮ) боловсруулах 110.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлыг гүйцэтгүүлэх 2025/57 тоот гэрээг 2025.04.04-нд ГЗБГЗЗГ-ын дэргэдэх Шинжлэх ухаан, технологийн зөвлөлийн гишүүнтэй байгуулж, гүйцэтгэлээр 31.6 сая төгрөгийн санхүүжилт олгосон;
- Өмнөговь аймгийн ГХБХБГ Алтайн өвөр сав газрын захиргаатай Хөв цөөрмийн ажлын захиалагчийн хяналт гүйцэтгэх ЗХ-2025/06 тоот гэрээ байгуулан ажлын гүйцэтгэлд 8.2 сая төгрөг олгосон.

**Судалгааны үр дүн:** Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан “Төрийн аудитын байгууллагаас төсвийн тухай хуулийн дагуу 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитад баримтлах ерөнхий чиглэл”-ийн дагуу аудитын явцад төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудаас авсан судалгааны үр дүнг нэгтгэлээ.

Монгол Улсын хөгжлийн 2026 онд баримтлах бодлогын тэргүүлэх чиглэлийн “Төрийн албаны шинэчлэлийг хийж, чиг үүргийн давхардлыг арилгах зорилгоор багш, эмч нараас бусад төрийн албан хаагчдын тоог 9 хувиар бууруулах замаар чадварлаг, цомхон, бүтээмжид суурилсан төрийн албыг бэхжүүлнэ” гэж заасны дагуу Монгол Улсын Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын орон тоог нийт 1,099 байхаар баталсан ба зохион байгуулалтын бүтцийн нэгж, албан тушаалтныг цомхотгож, гүйцэтгэлээр 1,058 орон тоотой ажилласан байна.

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 14.2.5 дахь заалт, Засгийн газрын 2019 оны 06 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Төрийн албан хаагчид нөхөн төлбөр олгох журам”-ын 8 дугаар зүйлийн 8.2, 8.4 дэх хэсэг, “Хөдөлмөрийн дотоод журам”-ыг үндэслэн алба хаагчдын хоолны мөнгөнд 4,500.00-35,000.00 төгрөг, унааны мөнгөнд 0-6,000.00 төгрөг зэрэг харилцан адилгүй байдлаар олгож байна.

Монгол Улсын Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын хэмжээнд 935.3 сая төгрөгийн 111 хурал цуглаан зохион байгуулах арга хэмжээ төлөвлөснөөс 929.3 сая төгрөгийн 109 хурал, зөвлөгөөн зохион байгуулсан байна.

Монгол Улсын Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын хэвлэл мэдээллийн үйл ажиллагаа эрхэлдэг 31 хуулийн этгээдтэй нийт 95.9 сая төгрөгийн гэрээ байгуулж гүйцэтгэлээр 89.0 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.

Монгол Улсын Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын үйл ажиллагаанд ашиглаж байгаа 8,611.8 сая төгрөгийн 127 төрлийн программ хангамжид тайлант онд 2,391.9 сая төгрөгийг зарцуулсан байна.

### 3.5.5 Хөтөлбөр арга хэмжээний хүрэх үр дүн, хэрэгжилт

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн хавсралтаар баталсан тус төсвийн ерөнхийлөн захирагчийн тайлант онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд 3 хөтөлбөрийн 15 хүрэх үр дүнг баталсан байна.

#### Хүснэгт 10. Хөтөлбөр арга хэмжээний хүрэх үр дүн, хэрэгжилт

Дэд дугаар	Төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлт				Хэмжих нэгж	Суурь он	Суурь түвшин	2025 оны зорилтот түвшин	Хүрсэн түвшин
<b>70426 Төрийн өмчийн эрхийг хэрэгжүүлэх</b>									
17.1	17.1.1	Төрийн өмчит хуулийн этгээдийн үр ашгийг нэмэгдүүлнэ.	17.1.1.1	Төрийн өмчит компанийн засаглалын үнэлгээ	хувь	2021	53.9	80	80
			17.1.1.2	Олон нийтийн шууд хяналтад оруулсан төрийн өмчит компани	тоо	2021	1	2	2
	17.1.2	Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, ашиглалт, хамгаалалтыг сайжруулна.	17.1.2.1	Төрийн болон орон нутгийн хуулийн этгээдийн эд хөрөнгийн мэдээллийн нэгдсэн системийг бий болгох	хувь	2021	40	90	95
			17.1.2.2	Улсын үзлэг, тооллогын мөрөөр авах арга хэмжээний хэрэгжилт	хувь	2021	97	100	99
	17.1.3	Төрийн өмчид тавих төрийн хяналтыг сайжруулж, хариуцлагын тогтолцоог боловсронгуй болгоно.	17.1.3.1	Төрийн өмчийн хяналт, шалгалт	тоо	2021	38	35	24
			17.1.3.2	Хууль, эрх зүйн шинэчлэлт	хувь	2021	70	90	-
<b>72201 Жендэрийн тэгш байдлыг хангах</b>									
17.2	17.2.1	Бүх нийтэд хүний эрх, жендэрийн боловсрол олгох үндэсний тогтолцоог хөгжүүлж, жендэрийн тэгш байдлыг хангах бодлого баримтална.	17.2.1.1	Тухайн жилийн сургалт, сургагч багш, сургалтад хамрагдсан удирдах ажилтан /УА/, төрийн албан хаагчийн тоо /ТАХ/, салбар, орон нутгийн жендэрийн бодлого, төлөвлөгөөний хэрэгжилт /	Хамрагдсан УА,ТАХ-ийн тоо	2021	Сургагч багш-154, УА-65, ТАХ-65	Сургагч багш-304, УА-80	502
								ТАХ-85	31
	17.2.2	Яамдын жендэрийн бодлого болон аймаг, нийслэл, дүүргийн жендэрийн дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг хангана.	17.2.2.1	Орон нутгийн жендэрийн тэгш байдлыг хангах чиглэлээрх үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан, батлуулахад, мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх	төлөвлөгөө	2021	30	31	31
			17.2.2.2	Орон нутгийн жендэрийн бодлого, төлөвлөгөөний хэрэгжилтэд оролцооны хяналт- шинжилгээ, үнэлгээ хийх чиглэлээр салбар хороонд мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх	Хороодын тоо	2021	9	21	19
17.2.3	Жендэрийн эрх тэгш байдлыг хангах талаар олон нийтийн	17.2.3.1	Хэвлэл мэдээллийн байгууллагын жендэрийн мэдрэмжтэй редакцын	Сургалтын тоо	2021	5	13	5	

Монгол Улсын Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

		ойлголт, мэдлэгийг дээшлүүлэх чиглэлээр сургалт, сурталчилгаа, судалгаа, дүн шинжилгээ хийх ажлыг зохион байгуулна.		бодлогыг бодитоор хэрэгжүүлэх сургалт зохион байгуулах.					
			17.2.3.2	Сэтгүүлч, нийгмийн ажилтан, эрх зүйч бэлтгэдэг их, дээд сургуулийн хөтөлбөрт жендэрийн хөтөлбөр тусгасан сургууль	тоо	2024	32	40	20
17.2.4		Эмэгтэйчүүдийн улс төрийн манлайллын сүлжээг өргөжүүлж, жендэрийн тэгш байдлын талаар улс төрийн нам, олон нийтийн ойлголт, хандлагыг нэмэгдүүлнэ.	17.2.4.1	Эмэгтэйчүүдийн манлайллын хөтөлбөрийг хэрэгжүүлэх санаачилгыг дэмжиж ажиллах	хөтөлбөр	-	-	1	5
			17.2.4.2	Жендэрийн эрх тэгш байдлыг хангах чиглэлээр хэрэгжүүлсэн сайн туршлагын талаарх сурталчилгаа	тоо	2021	3	7	7
17.2.5		Жендэрийн эрх тэгш байдлыг хангах бодлогыг хэрэгжүүлэх эдийн засаг, эрх зүйн баталгааг бүрдүүлэх, түүнийг боловсруулах ажлыг арга зүйн удирдлагаар хангаж, биелэлтэд хяналт тавих ажлыг зохион байгуулна.	17.2.5.1	Ажлын байрыг жендэрийн мэдрэмжтэй болгоход чиглэсэн бодлогыг шинэчлэн боловсруулж, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжид мөрдүүлэх арга хэмжээ	тоо	2023	T	2	1
			17.2.5.2	Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай конвенцын хэрэгжилтийн талаарх илтгэх хуудас	тоо	2024	1	1	100
<b>71504 Газрын зураглал, кадастр</b>									
17.3	17.3.1	Салбарын үйл ажиллагаанд мөрдөгдөж байгаа 38 хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллана..	17.3.1.1	2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээ	хувь	2023	100	100	95.7
	17.3.2	GNSS-ийн суурин станцын тоог 10-аар нэмэгдүүлнэ.	17.3.2.1	Монгол Улсын GNSS-ийн байнгын ажиллагаатай станцын сүлжээг өтгөрүүлэх	хувь	2023	43	61	53
	17.3.3	Нийслэл, 21 аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг газрыг эзэмшүүлэх, өмчлүүлэх, зүй зохистой ашиглах, хамгаалах, хуваарилахтай холбоотой дунд хугацааны төлөвлөлтийн баримт бичгээр бүрэн хангасан байна.	17.3.3.1	Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг шинэчлэх /Увс, Дундговь, Завхан/	тоо	2023	15	22	20
	17.3.4	Геопорталын хөгжүүлэлт хийгдэж орон зайн суурь 18 дэд сангийн мэдээллийг агуулсан сэдэвчилсэн зургийг хэрэглээнд нэвтрүүлсэн байна.	17.3.4.1	Геопорталаар дамжуулан төрийн бодлого, төлөвлөлт, шийдвэр гаргалтын “нэг газрын зураг”, иргэд, олон нийт, бизнесийн зориулалттай “нээлттэй газрын зураг” цахим үйлчилгээг улсын хэмжээнд нэвтрүүлэх	хандалт	2023	1,919,066	3,450,000	3,703,106
	17.3.5	Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө	17.3.5.1	Газрын тохиромжтой болон хэрэгцээт байдлын үнэлгээ, газар зохион	хувь	2023	50	100	85

Монгол Улсын Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

		боловсруулах, үйл ажиллагаа бүрэн цахимжсан байна.		байгуулалтын төлөвлөлт, хяналтыг боловсронгуй болгох					
17.3.6		Монгол Улсын аймаг, сумдын төвийг 1:1000-ны масштабтай байр зүйн зургаар хангасан байна.	17.3.6.1	Улсын хэмжээнд хот, суурин газрын төвийн 1:1000-ны масштабтай байр зүйн зураг, газар доорх шугам сүлжээний зургийг ITRF2020 солбицлын тогтолцоонд шилжүүлэх	хувь	2024	95	100	85
17.3.7		Газар зүйн орон зайн мэдээллийг нээлттэй болгож, эдийн засгийн өсөлтийг бий болгоно.	17.3.7.1	Хиймэл оюун ухаан, блокчэйн болон газар зүйн мэдээллийн системд суурилсан гурав болон дөрвөн хэмжээст газар, үл хөдлөх хөрөнгийн бүртгэл, үнэлгээ, татвар, төлбөрийн нэгдсэн системийг олон улсын жишигт нийцүүлэн хөгжүүлэх /Улсын хэмжээнд/	хувь	2024	10	12	11

Эх сурвалж: МУЕС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүн нь зорилтот түвшиндээ 92.5 хувь хүрсэн гэж тайлагнасан байна.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Монгол Улсын Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн төсвийн ерөнхийлөн захирагч, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн үйл ажиллагааг сайжруулах талаар холбогдох хууль тогтоомж, тушаал зааврын дагуу хөрөнгө бүртгэх, санхүүгийн нэгтгэсэн тайлангийн тодруулга, толилуулга бэлтгэхтэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Санхүүгийн аудитын газрын Ахлах аудитор П.Батцэцэг, Аудитор Ч.Мөнхбулган нар гүйцэтгэж, чанарын хяналтыг Аудитын менежер Э.Энхбаатар, газрын захирал, Тэргүүлэх аудитор Д.Баярсайхан нар тус тус хэрэгжүүлсэн.

Монгол Улсын Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2026 оны 4 дүгээр сарын 03-ны өдрийн ХЭГ/1084 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардал 762,114.0 сая төгрөгийн 1.0 хувиар тооцож 7,621.1 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тус байгууллага нь батлагдсан төсвийг хэтрүүлэлгүй, сул орон тоог хадгалах, дотоод цахим сүлжээ ашиглах зэргээр зардлыг хэмнэх арга хэмжээ авч ажилласан байна.

### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн нийцлийн асуудлаар нийт 6,146.6 сая төгрөгийн 33 зөрчил илрүүлсэнд, 6 төлбөрийн акт тогтоож, 1,341.1 сая төгрөгийн 9 албан шаардлага хүргүүлж, 4,805.5 сая төгрөгийн 18 зөвлөмж өгсөн.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой нийт 5,875.0 сая төгрөгийн 12 зөрчил илэрсэнд 1,165.8 сая төгрөгийн 4 албан шаардлага хүргүүлж, 4,709.2 сая төгрөгийн 8 зөвлөмж өгсөн байна.

Илрүүлэлт: ЖҮХАА нь Тайлант онд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 914.4 сая төгрөгийн 14 гүйлгээ, зарлагын 27.9 сая төгрөгийн 4 гүйлгээг мэдээлээгүй, 7 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.4.5-д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд хугацаанд нь иж бүрэн байршуулах.

#### Аудитын илрүүлэлт:

- Нийт 5,938.3 сая төгрөгийн мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан (Булган аймгийн ГХБХБГ 3,350.5 сая төгрөг, Нийслэлийн ГЗБА 2,318.6 сая төгрөг, ЭХЗХ 245.2 сая төгрөг, Дархан-Уул аймгийн ГХБХБГ 24.0 сая төгрөг);
- Нийт 1,830.0 сая төгрөгийн тайлант онд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын гүйлгээг мэдээлээгүй (ЖҮХАА 942.3 сая төгрөг, Дархан-Уул аймгийн ГХБХБГ 597.7 сая төгрөг, Өмнөговь аймгийн ГХБХБГ 124.2 сая төгрөг, Дундговь аймгийн ГХБХБГ 76.5 сая төгрөг, Завхан аймгийн зохицуулах зөвлөл 47.0 сая төгрөг, Баянхонгор аймгийн ГХБХБГ 29.0 сая төгрөг, Баянхонгор аймгийн зохицуулах зөвлөл 13.3 сая төгрөг);
- Төв аймгийн зохицуулах зөвлөл МУЗГ-ын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын дагуу шилэн дансны цахим хуудсанд цэс нээгээгүй байна.

#### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар бусад хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой нийт 279.6 сая төгрөгийн 15 зөрчил илэрсэнд 175.3 сая төгрөгийн 6 албан шаардлага хүргүүлж, 104.3 сая төгрөгийн 9 зөвлөмж өгсөн байна.

Илрүүлэлт: ЖҮХАА нь санхүүгийн үйл ажиллагаанд хүчингүй болсон анхан шатны баримт ашигласан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "үнэн зөв байх", Сангийн сайдын 2017 оны "Маягт загвар батлах тухай" 347 дугаар тушаалын 1 дүгээр хавсралттай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Сангийн сайдын 2017 оны "Маягт загвар батлах тухай" 347 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтад заасан анхан шатны баримтыг санхүүгийн үйл ажиллагаандаа ашиглаж хэвших.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл болон худалдан авах ажиллагаа зэрэг

нийцлийн асуудал нь Шилэн дансны тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль болон бусад хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

#### 4.5 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар зөрчлийг арилгах 1 албан шаардлага хүргүүлснийг нотлох баримтад үндэслэн хянаж үнэлэхэд бүрэн хэрэгжсэн байна.

Хүснэгт 11. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт /сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитаар		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	1	-	1	-	100.0
<b>Нийт дүн</b>	<b>1</b>	<b>-</b>	<b>1</b>	<b>-</b>	<b>100.0</b>

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Аудитын явцад дараагийн аудитаар дараах асуудлуудыг анхаарах шаардлагатай гэж үзсэн. Үүнд:

- Монгол улсын 2025 оны Төсвийн тухай хуулиар Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын улсын төсөвт төвлөрүүлэх ногдол ашиг болон төрийн өмчтэй байгууллагын байр талбайн түрээсийн орлогын 40 хувийг улсын төсөвт төвлөрүүлэх орлогын хэмжээг 101,600.0 сая төгрөг байхаар тогтоосон. Тайлант оны төсвийн жилээс эхлэн дээрх орлогуудыг Сангийн яамны Төв төрийн сангийн дансанд тайлагнадаг болсон тул дараагийн аудитаар орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийг нягтлах;
- Аймаг, нийслэлийн эрчим хүчний зохицуулах зөвлөлүүдийн санхүүгийн тайланг МУЕС-ын тайланд нэгтгэн гаргах нь оновчтой эсэх талаар холбогдох арга хэмжээ авч ажилласан эсэхийг дахин хянах.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэл тайлагналтай холбоотой нийт 23,827.4 сая төгрөгийн 69 алдаа<sup>1</sup> илэрснээс аудитын явцад 21,924.4 сая төгрөгийн 66 алдааг залруулж, 1,903.0 сая төгрөгийн 3 залруулагдаагүй алдаанд 1,879.2 сая төгрөгийн 1 албан шаардлага, 23.8 сая төгрөгийн 2 зөвлөмж өгсөн.

Аудитаар нийт 1,959.9 сая төгрөгийн 141 зөрчил<sup>2</sup> илэрсэнд 39.1 сая төгрөгийн 20 төлбөрийн акт тогтоож, 1,166.1 сая төгрөгийн 42 албан шаардлага хүргүүлж, 761.9 сая төгрөгийн 79 зөвлөмж өгсөн.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 3,862.9 сая төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 3,758.2 сая төгрөгөөр бага тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

### 5.1 Харьяа байгууллагуудын аудитаар илэрсэн алдаа, зөрчил

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 52 байгууллагын санхүүгийн тайлан нэгтгэснээс 26 байгууллагад дүгнэлт гаргаж, 25 байгууллагыг аудитын түүвэрт хамруулж, 1 байгууллага аудитад хамрагдаагүй байна.

Аудитаар харьяа байгууллагуудын 22 санхүүгийн тайланд “Өөрчлөлтгүй” дүгнэлт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар, Эрчим хүчний зохицуулах хороо, Говь-Алтай аймгийн ГХБХБГ болон Дархан-Уул аймгийн ГХБХБГ-ын санхүүгийн тайланд “Хязгаарлалттай” дүгнэлт өгсөн.

### 5.2 Төсвийн ерөнхийлөн захирагч

Илрүүлэлт: МУЕС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 3,862.9 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэнд, аудитын явцад 1,903.0 сая төгрөгийн залруулагдаагүй алдаанд 1,879.2 сая төгрөгийн 1 албан шаардлага 23.8 сая төгрөгийн 2 зөвлөмж хүргүүлж, 31.9 сая төгрөгийн зөрчилд 20 төлбөрийн акт, 1,166.1 сая төгрөгийн зөрчилд 42 албан шаардлага хүргүүлж, 761.9 сая төгрөгийн 78 зөвлөмж өгсөн, санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитаар нийт 6,146.6 сая төгрөгийн 33 зөрчил илэрсэнд 6 төлбөрийн акт, 1,341.1 сая төгрөгийн 9 албан шаардлага хүргүүлж, 4,805.5 сая төгрөгийн 18 зөвлөмж өгсөн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т *"санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх"*, 14 дүгээр зүйлийн 14.2-т *"Төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн удирдлагын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ"*, 14.2.10-т *"өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх"*, 15 дугаар зүйлийн 15.4.1-д *"төсвийн ерөнхийлөн захирагчийн энэ хуулийн 14.2.2, 14.2.3, 14.2.5, 14.2.8-д заасан болон төсвийн шууд захирагчийн энэ хуулийн 16.5-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх"*, 16 дугаар зүйлийн 16.5.6-д *"дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх"* гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: ТЕЗ-ийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүү, төсвийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналтын тогтолцоо, үйл ажиллагааг сайжруулах, аудитаар илэрсэн

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

алдаа, зөрчлийг арилгуулах, давтан гаргуулахгүй байх талаар нэгдсэн арга хэмжээг авч хэрэгжүүлэх, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах зөвлөмж өгөв.

### **5.3 Түүврийн байгууллага- Жендэрийн үндэсний хорооны Ажлын алба**

Аудитаар нийт 201.8 сая төгрөгийн 4 зөрчил илэрснээс 159.2 сая төгрөгийн зөрчлийг арилгах 1 албан шаардлага хүргүүлж, 42.6 сая төгрөгийн зөрчлийг арилгаж, давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өгсөн.

#### **5.3.1 Албан шаардлага**

Илрүүлэлт: Төсвийн захирагч нь хуульд заасан шаардлагын хүрээнд жилийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлээгүй, 9 хуулийн этгээдтэй 159.2 сая төгрөгийн шууд гэрээ байгуулж, санхүүжилт олгосон байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2-т *"Энэ хуулийн 31.2-т зааснаас бусад тохиолдолд нийт төсөвт өртөг нь шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаараас хэтрээгүй бараа, ажил, үйлчилгээг захиалагч шууд худалдан авч болно"*, 44 дүгээр зүйлийн 44.1-д *"Захиалагч батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батална"*, 44.3-т *"Захиалагч санхүүжилтийн эх үүсвэр батлагдсанаас хойш ажлын 10 өдрийн дотор худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг харьяалах дээд шатны төсвийн захирагчид цахим системээр илгээнэ"* гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хуульд заасан шаардлагын хүрээнд худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг боловсруулаагүй, шууд худалдан авалт хийсэн зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлсэн.

#### **5.3.2 Зөвлөмж**

##### **1. Зардалтай холбоотой асуудал**

Илрүүлэлт: Тайлант хугацаанд нийт 23.1 сая төгрөгийн гүйлгээг зардлын эдийн засгийн ангилал зөрүүлэн зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д *"төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах"*, 16 дугаар зүйлийн 16.5.5-д *"Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах"*, Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар"-тай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Батлагдсан төсвийн хүрээнд холбогдох эдийн засгийн ангиллаас зарцуулж хэвших.

##### **2. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал**

Илрүүлэлт: Байгууллагын үндсэн хөрөнгөд бүртгэлгүй "Жендэрийн үндэсний шинжээч, мэргэжилтэн, сургагч багш нарын сургалтын ерөнхий программ"-ын нэмэлт хөгжүүлэлтийг хийхэд тайлант онд 19.5 сая төгрөгийг зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д *"төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах"*, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т *"үнэн зөв байх"*, 20 дугаар зүйлийн 20.2.4-т *"нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах"*, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 1-д *"өөрт олгогдсон эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангаж, үйл ажиллагааныхаа зорилгод нийцүүлэн зориулалтын дагуу эзэмшиж, ашиглах"* гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Байгууллагын санхүүгийн тайланд бүртгэлгүй хөрөнгөд нэмэлт хөгжүүлэлтийн зардал гаргахгүй байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### 6.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/сая төгрөгөөр/

№	Шалгагдагч байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж		Албан шаардлага	
								Залруулсан		Залруулаагүй					
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
А	Б	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14
1	Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газар ТТЗ	3	3,951.4			3	3,951.4	2	2,072.3	1	1,879.2			1	1,879.2
2	Харилцаа холбооны зохицуулах хороо	1	1,067.2			1	1,067.2	1	1,067.2						
3	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар	5	2,898.8			5	2,898.8	5	2,898.8						
4	Бусад байгууллага	11	7,732.8	1	3,267.2	10	4,465.6	11	7,732.8						
5	Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газар	7	5,343.9	1	1,879.1	6	3,464.8	7	5,343.9						
6	Жендэрийн үндэсний хорооны Ажлын алба	2	23.8			2	23.8			2	23.8	2	23.8		
7	Архангай аймгийн ГХБХБГ	2	28.7			2	28.7	2	28.7						
8	Баянхонгор аймгийн ГХБХБГ	1	0.1			1	0.1	1	0.1						
9	Говь-Алтай аймгийн ГХБХБГ	4	1,035.7	1	772.6	3	263.1	4	1,035.7						
10	Говьсүмбэр аймгийн ГХБХБГ	1	10.3			1	10.3	1	10.3						
11	Дархан-Уул аймгийн ГХБХБГ	1	1,012.2	1	1,012.2			1	1,012.2						
12	Дорноговь аймгийн ГХБХБГ	5	43.5	1	19.0	4	24.4	5	43.5						
13	Завхан аймгийн ГХБХБГ	3	281.8			3	281.8	3	281.8						
14	Өмнөговь аймгийн ГХБХБГ	1	4.3	1	4.3			1	4.3						
15	Төв аймгийн ГХБХБГ	2	13.0			2	13.0	2	13.0						
16	Увс аймгийн ГХБХБГ	1	25.0			1	25.0	1	25.0						
17	Хөвсгөл аймгийн ГХБХБГ	5	61.4			5	61.4	5	61.4						
18	Хэнтий аймгийн ГХБХБГ	2	110.5			2	110.5	2	110.5						
19	Нийслэлийн ГЗБА	2	22.2			2	22.2	2	22.2						

Монгол Улсын Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

20	Говь-Алтай аймгийн зохицуулах зөвлөл	1	6.6			1	6.6	1	6.6						
21	Дархан-Уул аймгийн зохицуулах зөвлөл	3	2.5	1	1.1	2	1.5	3	2.5						
22	Дорноговь аймгийн зохицуулах зөвлөл	1	4.5			1	4.5	1	4.5						
23	Завхан аймгийн зохицуулах зөвлөл	3	62.7	2	61.2	1	1.5	3	62.7						
24	Орхон аймгийн зохицуулах зөвлөл	1	78.5			1	78.5	1	78.5						
25	Ховд аймгийн зохицуулах зөвлөл	1	6.0			1	6.0	1	6.0						
<b>Нийт дүн</b>		<b>69</b>	<b>23,827.4</b>	<b>9</b>	<b>7,016.7</b>	<b>60</b>	<b>16,810.7</b>	<b>66</b>	<b>21,924.4</b>	<b>3</b>	<b>1,903.0</b>	<b>2</b>	<b>23.8</b>	<b>1</b>	<b>1,879.2</b>

**6.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

*/сая төгрөгөөр/*

№	Шалгагдагч байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<b>А</b>	<b>Б</b>	<b>1</b>	<b>2</b>	<b>3</b>	<b>4</b>	<b>5</b>	<b>6</b>	<b>7</b>	<b>8</b>
1	Монгол Улсын Ерөнхий Сайд	1	-					1	-
2	Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газар ТТЗ	1	-			1	-		
3	Харилцаа холбооны зохицуулах хороо	3	25.1					3	25.1
4	Эрчим хүчний зохицуулах хороо	3	0.3	1	0.3	1	-	1	-
5	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар	6	137.9			4	112.5	2	25.4
6	Бусад байгууллага	19	237.8	1	0.6	6	134.9	12	102.3
7	Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газар	4	380.4			2	294.9	2	85.5
8	Жендэрийн үндэсний хорооны Ажлын алба	3	201.8			1	159.2	2	42.6
9	Архангай аймгийн ГХБХБГ	3	13.9	1	1.8	2	12.1		
10	Баян-Өлгий аймгийн ГХБХБГ	1	1.4	1	1.4				
11	Баянхонгор аймгийн ГХБХБГ	2	9.0			2	9.0		
12	Булган аймгийн ГХБХБГ	1	0.7					1	0.7
13	Говь-Алтай аймгийн ГХБХБГ	7	70.7			1	5.8	6	64.9
14	Говьсүмбэр аймгийн ГХБХБГ	2	6.7			1	6.7	1	-
15	Дархан-Уул аймгийн ГХБХБГ	5	16.3	1	1.5	2	6.8	2	8.0
16	Дорноговь аймгийн ГХБХБГ	2	7.6			1	7.6	1	-
17	Дорнод аймгийн ГХБХБГ	1	1.0	1	1.0				
18	Дундговь аймгийн ГХБХБГ	2	3.5			2	3.5		
19	Завхан аймгийн ГХБХБГ	3	26.5	1	1.6	2	24.9		
20	Орхон аймгийн ГХБХБГ	2	4.2			1	1.2	1	3.0
21	Өвөрхангай аймгийн ГХБХБГ	1	1.9			1	1.9		
22	Өмнөговь аймгийн ГХБХБГ	6	24.7	1	2.1	1	12.0	4	10.6
23	Сүхбаатар аймгийн ГХБХБГ	3	8.5					3	8.5
24	Сэлэнгэ аймгийн ГХБХБГ	1	9.3			1	9.3		
25	Төв аймгийн ГХБХБГ	2	3.3					2	3.3
26	Ховд аймгийн ГХБХБГ	1	0.5					1	0.5
27	Хөвсгөл аймгийн ГХБХБГ	3	145.8	1	2.8			2	143.0
28	Хэнтий аймгийн ГХБХБГ	1	3.6	1	3.6				
29	Нийслэлийн ГЗБА	4	330.4			1	257.9	3	72.5
30	Архангай аймгийн зохицуулах зөвлөл	5	48.0	1	3.0	4	45.0		
31	Баян-Өлгий аймгийн зохицуулах зөвлөл	2	33.7					2	33.7
32	Баянхонгор аймгийн зохицуулах зөвлөл	3	1.1	1	0.3			2	0.8

Монгол Улсын Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

33	Булган аймгийн зохицуулах зөвлөл	3	3.2					3	3.2
34	Говь-Алтай аймгийн зохицуулах зөвлөл	7	67.4	1	1.0	1	17.2	5	49.2
35	Говьсүмбэр аймгийн зохицуулах зөвлөл	4	10.5	1	0.8			3	9.7
36	Дархан-Уул аймгийн зохицуулах зөвлөл	1	0.5	1	0.5				
37	Дорноговь аймгийн зохицуулах зөвлөл	6	23.0	2	5.8	2	0.5	2	16.7
38	Дорнод аймгийн зохицуулах зөвлөл	1	4.0			1	4.0		
39	Завхан аймгийн зохицуулах зөвлөл	3	10.0	1	0.5			2	9.5
40	Орхон аймгийн зохицуулах зөвлөл	4	3.9					4	3.9
41	Сүхбаатар аймгийн зохицуулах зөвлөл	1	1.6					1	1.6
42	Төв аймгийн зохицуулах зөвлөл	4	45.8	2	3.3	1	39.2	1	3.3
43	Ховд аймгийн зохицуулах зөвлөл	4	34.4					4	34.4
<b>Нийт дүн</b>		<b>141</b>	<b>1,959.9</b>	<b>20</b>	<b>31.9</b>	<b>42</b>	<b>1,166.1</b>	<b>79</b>	<b>761.9</b>

6.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөгөөр/

№	Шалгагдагч байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс								
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Албан тушаалтны тоо
<b>А</b>	<b>Б</b>	<b>1</b>	<b>2</b>	<b>3</b>	<b>4</b>	<b>5</b>	<b>6</b>	<b>7</b>	<b>8</b>	<b>9</b>	<b>10</b>	<b>11</b>
1	Харилцаа холбооны зохицуулах хороо	2	67.5			2	67.5					
2	Эрчим хүчний зохицуулах хороо	1	245.2					1	245.2			
3	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар	1	-					1	-			
4	Бусад байгууллага	12	-	6	-	1	-	5	-			
5	Жендэрийн үндэсний хорооны Ажлын алба	2	942.3					2	942.3			
6	Баянхонгор аймгийн ГХБХБГ	3	479.3			2	479.3	1	-			
7	Булган аймгийн ГХБХБГ	1	3,350.5					1	3,350.5			
8	Дархан-Уул аймгийн ГХБХБГ	2	621.7			1	621.7	1	-			
9	Дундговь аймгийн ГХБХБГ	1	76.5			1	76.5					
10	Өмнөговь аймгийн ГХБХБГ	2	220.5					2	220.5			
11	Хөвсгөл аймгийн ГХБХБГ	1	82.8			1	82.8					
12	Нийслэлийн ГЗБА	1	-					1	-			
13	Баянхонгор аймгийн зохицуулах зөвлөл	1	13.3			1	13.3					
14	Говь-Алтай аймгийн зохицуулах зөвлөл	1	-					1	-			
15	Завхан аймгийн зохицуулах зөвлөл	1	47.0					1	47.0			
16	Төв аймгийн зохицуулах зөвлөл	1	-					1	-			
	<b>Нийт дүн</b>	<b>33</b>	<b>6,146.6</b>	<b>6</b>	<b>-</b>	<b>9</b>	<b>1,341.1</b>	<b>18</b>	<b>4,805.5</b>			